

Багшийн цахим журналын тухай

БСМС -ийн зүгээс “Цахим журнал 2.0” /Багшийн модуль/ хувилбарыг хөгжүүлж 2019-2020 оны хичээлийн жилд хэрэглээнд нэвтрүүлж эхлээд байна.

Багшийн цахим журналыг "Боловсролын салбарын мэдээллийн мэдээллийн систем" ашиглан хөтөлж байгаа үед хэвлэмэл журналыг давхардуулан хөтлөхгүй.

Цахим журналыг **компьютер** болон **гар утасны (Андройд, iOS) аппликэйшн** ашиглан хөтлөх боломжтой.

Багш цахим журнал хөтөлснөөр эцэг эх, асран хамгаалагч нь суралцагчийн ирц, сурлагын үнэлгээ, ахиц дэвшлийн талаарх мэдээллийг "Эцэг эхийн систем" -ээр дамжуулан авах боломжтой болно.

Цахим журнал хөтлөхөөс өмнө дараах 3 бүртгэлийг урьдчилан хийсэн байх шаардлагатай.

1. Аль бүлэгт, ямар хичээлийг, хэн багш, хэддүгээр цагт заахыг бүртгэсэн байх /Ээлжит хичээл модуль - Сургалтын менежер эсвэл Анги удирдсан багш/
2. Хэрэв тухайн хичээлийг суралцагч сонгон судалдаг бол хичээл сонголтыг бүртгэх /Хичээл сонголт модуль - Сургалтын менежер эсвэл Анги удирдсан багш/
3. Хичээл бүрээр бүлэг сэдвийн жагсаалт/**Бүлэг сэдвийн сан***/ бүртгэсэн байх /Бүлэг сэдвийн сан - ЗАН эсвэл Хичээл заадаг багш/

Бүлэг сэдвийн сан*

Сургуулийн хэмжээнд хичээл бүрээр бүлэг сэдвийн санг системд бүртгэснээр тухайн хичээлийг заадаг багш нар дундаа ашиглах боломжтой. Мөн нэг багш тухайн бүлэг сэдвийн сангаа өөрийн хичээл заадаг бүх ангийн журнал хөтлөхдөө дахин бичихгүйгээр ашиглаж болно.

Хэрэв өнгөрсөн хичээлийн жилд багш цахим журнал хөтлөхдөө бүлэг сэдэв болон багшийн тэмдэглэл хөтөлсөн бол “Бүлэг сэдвийн сан” -гаасаа дахин ашиглаж болно.

Бүлэг сэдвийн санг сургуулийн "Заах аргын нэгдэл" -ийн багш нар хэлэлцэж батлаад хичээл бүрээр нэгдсэн байдлаар бүртгэхийг зөвлөж байна.

Цахим журнал хөтлөх

Хичээлийн багш дараах үйл ажиллагааг цахим журнал хэсэгт хөтлөх боломжтой.

- Ирц бүртгэх
- Багшийн тэмдэглэл буюу ээлжит хичээлийн үйл ажиллагааг бүртгэх
- Үнэлгээ бүртгэх
 - Үнэлгээ 1 - Бүлэг сэдвийн үнэлгээ
 - Үнэлгээ 2 - Хагас жилийн үнэлгээ
- Журнал хэвлэх